

Болгарын бэлгэ тэмдэг болсон Сарнайн баяр

Болгарын бэлгэ тэмдэг болсон Сарнайн баярыг анх 1903 оноос тэмдэглэж эхэлсэн бөгөөд зургаадугаар сарын эхний амралтын өдрүүдэд, нийт 3 хоногийн хугацаанд өргөн дэлгэр тэмдэглэдэг аж.

Тус наадам нь Казанлак хотын ойролцоо орших сарнайн тариалангийн нугад сарнай түүх ёслолоор эхэлдэг аж. Баярын энэ арга хэмжээг БНБУ-ын Ерөнхийлөгч нээж үг хэлсний дараа тус улсын төр, засгийн болон иргэд, олон нийтийн төлөөлөгчид сарнай түүх ёслол үйлддэг нь нэн сонирхолтой

Дээрх ёслолын дараа бүгд Казанлак хотод эргэн ирж, хотын төв талбайд болдог сарнайн баярын жагсаалд оролцоно. Энэхүү жагсаалд бүх шатны сургуулиудын сурагчид, оюутнууд үндэсний хувцсаараа гоёж суралцагсад сургуулийнхаа туг далбааг өндөрт өргөн явж өнгөрнө, тэднийг залган албан байгууллага, компани, цэргийн анги нэгтгэлийн төлөөлөгчид ёслол төгөлдөр оролцдог. Баярын жагсаалд оролцон алхаж буй хүмүүс нь гартаа том сагс дүүрэн сарнай цэцгийн дэлбээ барьж явах ба энэхүү дэлбээгээ үзэгчидрүү чиглүүлэн шидэж аз жаргалыг хүсдэг байна.

Энэ үеэр язгуур урлагийн янз бүрийн хамтлагийн тоглолт, гар урлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг нь дэлхийн олон орны жуулчдын сонирхлыг ихээхэн татдаг ажээ.

Энэхүү баярын үеэр “Сарнайн хатан хаанд” өргөмжлөх уралдааныг 1975 оноос эхлэн зохион байгуулдаг болсон ба энэхүү хэргэмийг ямар ч насны эмэгтэй хүртэх боломжтой.

Rose наадамд ирсэн зочдыг Болгарын уламжлалт зан үйлийн нэг болох нэхмэл гар урлалын хувцас хэрэглэлээр хангаж, сарнайн дэлбээтэй гамбираар дайлж, шавран ваар хэрхэн урлах талаар талбай дээрээ дэлгэн харуулдаг аж.

Болгарын үзэсгэлэнт сайхан баяр нь "ного" ардын бүжгээр төгсдөг бөгөөд түүнийг хүссэн хэн бүхэн Болгарын уу үгүй юу гэдгээс үл хамааран хамтдаа бүжиглэнэ.

Болгарын Сарнай цэцгийн баярыг үзэхээр гадны орнуудаас 100,000 гаруй зочид төлөөлөгч, жуулчид ирдэг гэсэн тооцоо байдаг байна.



